

## 8-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР А ХУВИЛБАР

Хугацаа: 60 минут

Нийт 20 оноо

### Амьтныг шинжихүй

Манай ард түмэн эрт үеэс амьтны гадаад төрх, бие бүтэц, ааш араншин, амьдралын зүй тогтлыг сонирхон ажиглаж, асар их мэдлэг, туршлага хуримтлуулжээ. Жишээлбэл: Чоно бол их муу санаатай. "Муу хүн чөлөөнд, чоно бороонд" гэдэгчлэн тэнгэр муудахаар хот хороо руу сэм гэгддэг.

Чоно бага үдийн орчим заавал унтана. Нэг нь харуулд гарна. Унтахын өмнө 1-2 удаа оцойн өндийж бараа харна. Байраа ойр ойрхон солино. "Адууны бүтэн хомоол уугьж дуусах хугацаанд бүрэн унтдаг" гэж хашир анчид ярьдаг.

Харин үнэг бол хагас хомоол уугьж дуусах зуур дугжирна. "Бөх унтсан үнэгний хоёр чих нь хайчлах маягаар үргэлж хөдөлж байдаг" гэж хууччуул ярьдаг билээ.

Зэрлэг гахай явдаг зам жимээсээ хазайх нь ховор, үнэг зальтай боловч мартамхай нь үлэмж. Ардууд энэ мэт араншинг мэдэж ан гөрөөний ажилдаа ихэд ашигладаг байв.

1. Дээрх эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлоорой. /1 оноо/

- A. Амьтдын амьдралын тухай
- B. Чоно их муу санаатай тухай
- C. Анчдын ан агнах тухай
- D. Амьтны араншинг судлан, ан гөрөөний ажилдаа ашигладаг тухай

2. Зөв харгалзуулсан хэсгийг олоорой. /2 оноо/

- A. 1б, 2в, 3г, 4а      B. 1в, 2б, 3а, 4г      C. 1в, 2б, 3г, 4а      D. 1б, 2г, 3в, 4а

1. Баримт	A. Энэ мэт араншинг мэдэж ан гөрөөний ажилдаа ихэд ашигладаг
2. Үзэл бодол	B. Чоно бол их муу санаатай.
3. Мэдрэмж	B. Нэг нь харуулд гарна.
4. Дүгнэлт	Г. Хоёр чих нь хайчлах маягаар үргэлж хөдөлж байдаг

3. "Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад балархай эгшгийг гээнэ" гэсэн дүрэмд тохирох үгсийг олж дугуйлаарай. /2 оноо/

- A. Амьтны, хуримтлуулжээ, тогтлыг
- B. Араншин, амьдралын, туршлага
- C. Туршлага, солино, гөрөөний
- D. Жимээсээ, зальтай, мартамхай

4. "Муу хүн чөлөөнд, чоно бороонд" хэмээх хэлцийн утгыг тайлбарлаарай. /1 оноо/

- A. Муу санаархах
- B. Далимдуулах, сул талыг ашиглах
- C. Залилаж, хохироох
- D. Аз тохиох, баярлах

5. "Ардууд амьтны араншинг мэдсэн тул ан гөрөөний ажилдаа ихэд ашигладаг байв." Нийлмэл өгүүлбэрийг холбосон хэрэглүүрийг тодорхойлоорой. /1 оноо/

- A. тул – учир шалтгааны утгатай холбоос
- B. тул – цагийн утгатай холбоос
- C. тул – байдлын утгатай холбоос
- D. тул- хэвийн дагавар

6. .... нь нэг юмыг нөгөөтэй нь харьцуулах, уран дүрслэлийн арга бөгөөд шиг, мэт адил, гэх холбоосоор танигдаж байдаг. /2 оноо/

A. Адилтгал      В. Ихэсгэл      С. Тойруулал      D. Зүйрлэл

7. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу Борзооны явдал” туужийн доорх хэсэгт ямар хэрэг явдлын талаар өгүүлж байна вэ? /2 оноо/

“... - Борзоон гэдэгт чинь хууртаад хүүхдүүд жинхэнэ хулгайчийг барих гэж бодохоо ч больсон. Ингэж “Борзоон” гэдэг нэрээр халхавч хийгээд нэг нөхөр манай сургуулийг санаа амар сүйтгэж байна. Тэр хулгайчид санаа амар хулгай дээрэм хийж явах бүх бололцоо, үүд хаалгыг чи нээж өгсөн... - - Үгүй ээ, багш аа. Тийм юм байхгүй... Дуугүй бай, нөхөр минь...”

- A. Сурагч бодлогогүй ярианаасаа болж гүтгэгдэж буй тухай
- B. Сурагч Борзоон нэрээр халхавч хийн хулгай хийсэн тухай
- C. Багш хулгайчийг барьж, байцааж байгаа тухай
- D. Хүүхдүүд хулгайчийг барих гэж бодохоо больсон тухай

8. Гүүр хэмээх үгийг зөв бичсэн хэсгийг олж дугуйлаарай. /2 оноо/

A.

ᠭᠦᠮᠡᠭᠦ

B.

ᠭᠦᠮᠡᠭᠦ

C.

ᠭᠦᠮᠡᠭᠦ

D.

ᠭᠦᠮᠡᠭᠦ

9. “сонус+гчи”= сонсогч бүтээврийн нийлцийг зөв бичсэн хэсгийг олоорой. /2 оноо/

A.

ᠰᠣᠨᠰᠣᠭᠴᠢ

B.

ᠰᠣᠨᠰᠣᠭᠴᠢ

C.

ᠰᠣᠨᠰᠣᠭᠴᠢ

D.

ᠰᠣᠨᠰᠣᠭᠴᠢ

## 8-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР В ХУВИЛБАР

Хугацаа: 60 минут

Нийт 20 оноо

### ЗООГ ТАВИХ ДОХИО НАРИЙН ЖУРАМТАЙ

Мах нэг бүр дор дороо учир утгатай байх нарийн журам бий. Өөрөөр хэлбэл мах нэг бүрт хүндэтгэлийн зэрэг буй.

Мөч махыг зочинд тавьж өгөхдөө малын хөл газарт тулдаг чигийг зочин зүг харуулан таваглаж өгнө. Зочны өөдөөс богт чөмөгний толгойг хандуулж тавибал "Чамд нударга өгье" гэсэнтэй адил дохио. Богт чөмөгний нөгөө үзүүрээр харуулж тавибал "Чамд заналтай" гэсэн дохио. Учир нь тэр үзүүр хөмхийгөө зууж буй мэт дүрстэй юм. Иймд зочинд богт чөмөг тавьж өгөхийг бүрэн цээрлэдэг. Хэрэв өгвөл дээрх хоёр дохионы аль нэг гэж ойлгогддог байсан.

Мөн хүзүүг дангаар нь зочинд тавьж өгвөл "Хүний хүн хүчгүй, хүзүүний мах амтгүй" гэсэн дохио болно. Мөн богино хавиргыг айлчин зочинд тавьж өгдөггүй. Бас уураг сүүл, шагай чөмөгтэй хамт зочинд өгвөл тэр нь "Та бурхан гэсэн дохио. Уул нь энэ хоёрыг "Бурхны хувь" гэдэг.

Өвчүүний бүдэрхийг зочинд өгвөл "Унасан морь чинь бүдрэг" гэсэн дохио тул цээртэй.

Харийн хүнд хонины дал, шаант, хавирга, сээр зэрэг мах талбих нь цээртэй. Өөрийн бөгөөд хүндтэй хүнд өгдөг зууш юм.

Монголчууд аливаа үйлд ямагт бэлгэ дэмбэрлийг бодож, сайн сайхныг хүсдэг, ард түмэн бөлгөө.

### Ажиллах даалгавар:

1. Дээрх эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлоорой. /1 оноо/

- A. Монгол ард түмний тухай
- B. Зоог засах тухай
- C. Бэлэг дэмбэрэлийн тухай
- D. Зочин дайлах ёсын тухай

2. Зөв харгалзуулаарай. /2 оноо/

- A. 1в 2а 3г 4б B. 1б 2в 3б 4г C. 1в 2б 3г 4а D. 1б 2г 3в 4а

1. Баримт	A. Хүний хүн хүчгүй, хүзүүний мах амтгүй
2. Хэлц	B. Монголчууд ямагт бэлгэ дэмбэрлийг бодож, сайн сайхныг хүсдэг, ард түмэн.
3. Мэдрэмж	B. Богино хавиргыг айлчин зочинд тавьж өгдөггүй.
4. Дүгнэлт	Г. Богт чөмөгний үзүүр хөмхийгөө зууж буй мэт дүрстэй юм

3. "и"-гээс бусад богино эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эгшгийг гээгнэ" дүрэмд тохирох үгийг олоорой /2 оноо/

- A. Хавиргыг B. Өвчүүний C. Хүний D. Чигийг

4. "Хүний хүн хүчгүй, хүзүүний мах амтгүй" хэмээх хэлцийн утгыг тайлбарлаарай. /1 оноо/

- A. Хүн тустай зүйл хийх
- B. Хүч чадалгүй болох
- C. Өөрийн биш зүйл үнэ цэнгүй байдаг
- D. Өөрийн зүйлийн үнэ цэнийг мэдэх

5. "Унасан морь чинь бүдрэг" гэсэн дохио тул өвчүүний бүдэрхийг зочинд өгдөггүй. Нийлмэл өгүүлбэрийг холбосон хэрэглүүрийг тодорхойлоорой. /1 оноо/

- A. тул – байдлын утгатай холбоос
- B. тул – цагийн утгатай холбоос
- C. тул – нөхцөлийн утгатай холбоос
- D. тул – учир шалтгааны утгатай холбоос

6. Үндэсний бичгээс уншаад кирилл рүү зөв хөрвүүлсэн хэсгийг олоорой. /2 оноо/

- a. Хүн дэлхийтэй гүн холбоотой.
- b. Хүн дэлхийтэй хүйн холбоотой.
- c. Хүн далайтай хүйн холбоотой
- d. Хүн дэлхийтэй хүйн холбоогүй.

ᠬᠦᠨ  
ᠳᠡᠯᠬᠢᠢᠲᠡᠢ  
ᠬᠦᠢᠨ  
ᠬᠣᠯᠪᠣᠭᠣᠢ

7. гэсэн бичлэгт тохирох үг аль нь вэ?. /2 оноо/

- A. Хайр чулуу
- B. Хуушуур хайр
- C. Эхийн хайр
- D. Мөс хайрах

8. Аливаа баяр ёслол, хурим найрын үед ирээдүйн аз жаргал, сайн сайхныг бэлгэдэн хэлдэг зан үйлийн уран шүлэглэлийг ..... гэнэ. /2 оноо/

- A. Магтаал
- B. Зүйр цэцэн үг
- C. Сургаал үг
- D. Ерөөл

9. “Эрийн сайн Хан Харангуй” туульсын дараах хэсэгт уран дүрслэлийн ямар арга илэрч байна вэ? /2 оноо/

Хавиргандаа завсаргүй  
Харцагандаа үегүй

- A. багасгал
- B. ихэсгэл
- C. тойруулал
- D. Төлөөлөл

## 8-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР С ХУВИЛБАР

Хугацаа 60 минут

Нийт 20 оноо

### Хулсны баавгай буюу панда

Дэлхий дээр хулсны баавгай нь 2 төрөл байдаг. Нэг нь том хулсны баавгай нөгөөх нь жижиг буюу улаан хулсны баавгай. Том нь бидний сайн мэдэх хар цагаан өнгө холилдсон арьстай панда юм. Энэ панда нь Хятад Төвөдийн ойд амьдардаг. Том панда 1.5 метр орчим өндөртэй, 100 кг орчим жинтэй. Бамбаруушаа 95-160 хоног тээдэг. Ихэнхдээ 1-2 бамбарууш гаргадаг бөгөөд 90-130гр жинтэй төрдөг. Эх нь хамгийн түрүүлж гаргасан бамбаруушаа л халамжилж өсгөх бөгөөд 2 дахийг нь голдог. 2000 оны үед БНХАУ-д хулсны баавгайг хамгаалах үндэсний хороо байгуулсан бөгөөд тэр үеэс эхдээ гологдсон бамбаруушуудыг амьтны хүрээлэнгийн ажилтнууд өсгөдөг болжээ. Хулсны баавгай ганцаараа амьдардаг их залхуу унтах, идэх, заримдаа тоглох зэргээр тэдний ажил хязгаарлагдана. Дэлхийн байгаль хамгаалах сангийн бэлгэ тэмдэг нь хулсны баавгай буюу панда юм. Эрдэмтдийн үзэж байгаагаар байгаль дээр 1600 толгой хулсны баавгай үлджээ. 1970-аад онд хятадууд албан харилцаагаа сайжруулах зорилгоор гадны орнуудад хулсны баавгай бэлэглэдэг байжээ. Харин 1984 оноос бэлэглэхээ больж 10 жилийн хугацаатай түрээсэлдэг болсон аж. Хулсны баавгайг агнахыг хуулиар хоригложээ.

1. Эхийн сэдвийг тодорхойлоорой. /1 оноо/  
А.Хулсны баавгайн амьдрал, онцлогийн тухай  
В.Хулсны баавгай бэлэглэдэг тухай  
С.Хулсны баавгай бамбаруушаа голдог тухай  
D.Хоёр төрлийн баавгайны тухай

2. Зөв харгалзуулсан хэсгийг дугуйлаарай /2 оноо/

A. 1d 2c 3a 4b    B. 1a 2b 3c 4d    C. 1в 2d 3a 4c    D. 1c 2a 3d 4b

1.Хуульзүйн баримт	A. Магнай тэнийх
2.Тоон баримт	B. залхуу, идэх, унтах, тоглох
3. Хэлц	C. Том панда 1.5 метр орчим өндөртэй, 100 кг орчим жинтэй.
4.Хөдөлгөөн илтгэх үгс	D. Хулсны баавгайг агнахыг хуулиар хоригложээ.

3. “үзүүлье” гэсэн үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлаарай /2 оноо/

A. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд “е” залгахдаа эгшгийг гээж бичнэ.  
B. Эм үгэнд “е” залгахдаа шууд бичнэ.  
C. Эм үгэнд “ь” нь зөөлрүүлэх үүрэгтэй.  
D. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд “е”-г залгахдаа “ь”-ээр тусгаарлана.

4. “Гол харлах ” хэлцийн утгыг тайлбарлаарай. /1 оноо/

A. Харамсах, өлсөх    B. Хоосрох, зовох    C. Дотор муухайрах    D. Санаа зовох

5. “Эрдэмтдийн үзэж байгаагаар байгаль дээр 1600 толгой хулсны баавгай үлджээ. Хулсны баавгайг агнахыг хуулиар хоригложээ.” хоёр өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлбэр өгүүлбэр болгоход тохирох холбох үгийг олж дугуйлаарай /1 оноо/

A. буюу    B. бөгөөд    C. учраас    D. Тул

6. “Гууль” /гаули/ хэмээх үгтэй ижил хэлбэрээр бичих үгийг олоорой. /2 оноо/

A.

ᠭᠦᠭᠦᠷ

B.

ᠭᠦᠭᠦᠷ

C.

ᠭᠦᠭᠦᠷ

D.

ᠭᠦᠭᠦᠷ

7. “Гүүр” хэмээх үгийг зөв бичсэнийг олоорой. /2 оноо/

A.

ᠭᠦᠭᠦᠷ

B.

ᠭᠦᠭᠦᠷ

C.

ᠭᠦᠭᠦᠷ

D.

ᠭᠦᠭᠦᠷ

8. .... гэж холбоц хийгээд аялгын нэгэн хэмнэлд захирагдан, тодорхой утга төгссөн айзам буюу хэд хэдэн шадын нийлбэрийг хэлдэг. / 2 оноо/

A. Бадаг                  B. Мөр                  C. Шад                  D. Холбоц

9. Д.Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч” зохиолын доорх хэсэгт дүрийг тодруулахад орчин хэрхэн нөлөөлж байна вэ? /2 оноо/

“...Доодтойд суугаа минчгэр хүрэн царайтай цээжин бие нь дан хөх даалимбан тэрлэгтээ багтаж ядсан бүдүүн авгай, - Ээ тийм эвий минь, энэ хорвоо гэдэг чинь ер яасан хэцүү гэж өгүүлэнгүүтээ говь нутгийн халуун хуурай агаарт гандан борлохынхоо зэрэгцээгээр сааль сүүндээ зөөлөрсөн гараа нүүрэндээ аваачин енгэнэв ... ”

- A. Гандаж борлосон гар нь говь нутгийн хүн гэдгийг нь илтгэж байна.
- B. Доодтойд сууж байгаа нь энэ гэрийн эзэгтэй гэдгийг нь илтгэж байна.
- C. Енгэнүүлэн уйлж буйгаар нь уй гашуу тохиолдсоныг илтгэж байна.
- D. Хэлсэн үг нь хорвоогийн хэцүүд харуусан гасалсан хүнийг илтгэж байна.

## 8-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР D ХУВИЛБАР

Хугацаа 60 минут

Нийт 20 оноо

### Чага мөөг

Чага мөөг нь хус модыг шимэн ургадаг, хагас дугуй хэлбэртэй, гаднаас харахад барзгар хар өнгөтэй олон тооны зураас бүхий гадаргуутай чулуу мэт хатуу ургамал юм. Намар 9 дүгээр сараас 6 сар хүртэл түүхэд тохиромжтой 2 жилийн дотор чанараа алддаггүй. Найрлагадаа элэг цэвэршүүлэх, хоргүйжүүлэх, хавдрын эсийн ургалтыг зогсоох, хавдрын эсийг хордуулж устгадаг хүчлийг агуулдаг. Чага мөөг нь хус модноос хүчлийг шимэн авч, өөртөө хуримтлуулдаг. Чага мөөг нь дархлааг сайжруулах тархины эд эсийн бодисын солилцоо, цусан хангамжийг тэнцвэржүүлэх, биеийн дасан зохицох чадвар болон ачаалал даах чадварыг нэмэгдүүлэх гэх мэт олон талын ач тустай. Чихрийн шижин өвчтэй хүмүүс уухад тохиромжтой. Хатаасан чага мөөгийг нунтаглан, 1 цайны халбагыг 1 аяга 80-900С халуун усанд хийж, 10-15 минут байлгаад ууна. Чага мөөгөөр эмчилгээ хийж байх үед сүү, ногоо голлосон хоол хүнс хэрэглэх нь тохиромжтой.





1. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг тодорхойлоорой. /1 оноо/
  - A. Намар 9 дүгээр сараас 6 сар хүртэл түүхэд тохиромжтой 2 жилийн дотор чанараа алддаггүй.
  - B. Чага мөөг нь эрүүл мэндэд тустай, эмчилгээнд хэрэглэдэг ургамал юм.
  - C. Чага мөөгөөр эмчилгээ хийж байх үед сүү, ногоо голлосон хоол хүнс хэрэглэх нь тохиромжтой.
  - D. Чихрийн шижин өвчтэй хүмүүс уухад тохиромжтой
2. “**захицгаа**” гэсэн үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлаарай /2 оноо/
  - A. Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг “и” болно.
  - B. Эгшигт гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг “и” болно.
  - C. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг “и” болохгүй.
  - D. Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчийн дараа эгшигт гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг “и” болно.
3. Хоёр өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлбэр өгүүлбэр болгоход тохирох холбох үгийг олж дугуйлаарай /2 оноо/

*Найрлагадаа элэг цэвэршүүлэх, хоргүйжүүлэх, хавдрын эсийн ургалтыг зогсоох, хавдрын эсийг хордуулж устгадаг хүчлийг агуулдаг. Чага мөөг нь эрүүл мэндэд тустай, эмчилгээнд хэрэглэдэг ургамал юм.*

  - A. буюу
  - B. бөгөөд
  - C. учраас
  - D. Тул
4. Зөв харгалзуулсан хэсгийг дугуйлаарай. /1 оноо/
  - A. 1b 2a 3c 4d
  - B. 1b 2a 3c 4d
  - C. 1d 2c 3a 4b
  - D. 1d 2a 3c 4b

1.Тоон баримт	A. Ам алдвал барьж болдоггүй, Агт алдвал барьж болдог
2. Чага мөөгний гадаад шинж	B. цэвэршүүлэх, хоргүйжүүлэх, хордуулах, сайжруулах, тэнцвэржүүлэх, нэмэгдүүлэх
3. Хэлц	C. хагас дугуй хэлбэртэй, барзгар хар өнгөтэй олон тооны зураас бүхий гадаргуутай чулуу мэт хатуу
4. Ач тусыг илтгэсэн үйл үгс	D. 1 цайны халбагыг 1 аяга 80-900С халуун усанд хийж, 10-15 минут байлгаад ууна.

5. “Нүд өөхлөх” хэлцийн утгыг тайлбарлаарай. /1 оноо/  
 А. юмыг тоохоо болих  
 В. өвдөх, зовох  
 С. хараа муудах  
 D. санаа зовох
6. Зөв харгалзуулсан хэсгийг дугуйлаарай. /2 оноо/  
 А. 1a 2c 3b 4d                      В. 1b 2d 3c 4a                      С. 1a 2d 3b 4c                      D. 1c 2a 3b 4d  
 1.Шүлэг                                      а. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу борзооны явдал”  
 2.Өгүүллэг                                б. Б.Ринчен “Монгол хэл”  
 3.Туульс                                    с. “Эрийн Сайн Хан Харангуй”  
 4.Тууж                                        d. “Цүнхтэй инээд”
7. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу Борзооны явдал” туужийн Борзоон нь ..... дүр юм. /2 оноо/  
 А. гол дүр            В. туслах дүр            С. эсрэг дүр            D.эерэг дүр
8. “нэгүхү-ийн эмүн-э нутуг-йиан сонгу” гэсэн галигийг зөв бичсэн хэсэг аль вэ /2оноо/

A.	B.	C.	D.
			

9. Үйл үгийн хэвийн “-га” дагавартай үгийг олоорой. /2 оноо/

A.	B.	C.	D.
			



## 8-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР Е ХУВИЛБАР

Хугацаа 60 минут

Нийт 20 оноо

### Цөлийн аргамжин цэцэг

Цөлийн аргамж цэцэг буюу цагаан гоёог нутгийнхан говийн шидэт ургамал гэж нэрлэдэг. Энэхүү ургамал нь улаан, цагаан гэсэн хоёр төрөл байдаг. Гоёо нь заг мод байгаа газарт ургадаг. Гаднаас нь харахад навч нахиагүй элсэнд зориуд зоочихсон юм шиг харагддаг. Харахад царай муутай ч “Гоёо” нэрэндээ таарсан гайхамшигтай ургамал юм. Иш нь бүдүүн, зөөлхөн. Зүсэж үзвэл дотроо цагаан эдийг агуулж, сүү шиг шүүсийг ялгаруулна. Нэг дор ихэвчлэн 2-4 гоёо ургадаг. Заримдаа арваад гоёо нэг дор ургасан байх нь таарна. Цусны даралт ихдэх, чихрийн шижин, мэдрэлийн өвчин, толгой өвдөх, үе мөч өвдөх, элэг бөөрний үрэвслийг анагаах шидтэй. Цус төлжүүлэх онцгой чадвартай учир говийнхон “залуужуулах шидтэй” гэж ярих нь ч бий. Мөн анагаах ухааны сударт гоёог сэтгэлийн түгшүүр арилгах, уур уцаар тайлахаас гадна ходоодны хүчил ихтэй хүмүүс хатаасан гоёог зажилбал сайн, жирэмсэн эмэгтэйчүүд болон цөсний өвчтэй хүмүүс гоёо хатааж, бага хэмжээгээр зажлахад цээж хорсох зовуурь арилдаг гэж тэмдэглэжээ.

- Эхийн сэдвийг тодорхойлоорой. /1 оноо/
  - Шидэт ургамлыг эмчилгээнд хэрэглэх тухай
  - Цөлийн аргамжин цэцгийн тухай
  - Эрүүл мэндэд тустай, эмчилгээнд хэрэглэдэг ургамлын тухай
  - Гоёо нэрэндээ таарсан гайхамшигт цэцгийн тухай
- Хоёр өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлбэр өгүүлбэр болгоход тохирох холбох үгийг олж дугуйлаарай. /2 оноо/

*Цөлийн аргамж цэцэг буюу цагаан гоёо нь цусны даралт ихдэх, чихрийн шижин, мэдрэлийн өвчин, толгой өвдөх, үе мөч өвдөх, элэг бөөрний үрэвслийг анагаах шидтэй. Нутгийнхан говийн шидэт ургамал гэж нэрлэдэг.*

  - буюу
  - бөгөөд
  - учир
  - Тул
- Зөв харгалзуулсан хэсгийг дугуйлаарай. /2 оноо/
  - 1b 2a 3c 4d
  - 1b 2a 3c 4d
  - 1d 2c 3a 4b
  - 1d 2a 3c 4b

1.Тоон баримт	А. анагаах, залуужуулах, төлжүүлэх, тайлах, арилгах
2. Гоёоны гадаад шинж	В. 2-4 гоёо ургадаг. Заримдаа арваад гоёо нэг дор ургасан байх нь таарна.
3. Хэлц	С. Толгой цохих
4. Ач тусыг илтгэсэн үгс	Д. навч нахиагүй элсэнд зориуд зоочихсон юм шиг, иш нь бүдүүн, зөөлхөн.

- “Савангийн хөөс шиг” хэлцийн утгыг тайлбарлаарай. /1 оноо/
  - бат бөх сайтай
  - зальтай байх
  - амархан эвдрэх
  - уур омогтой
- “урьчих” гэсэн үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлаарай. /1 оноо/

- A. Зөөлөрсөн эгшигт гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг хэвээрээ байна
- B. Зөөлөрсөн эгшигт гийгүүлэгчийн дараа эгшигт гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг хэвээрээ байна
- C. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг хэвээрээ байна
- D. Эгшигт гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг “и” болно.

6. “Эрийн сайн Хан Харангуй” туульсын дараах хэсэгт уран дүрслэлийн ямар арга илэрч байна вэ? /2 оноо/

Хавиргандаа завсаргүй

Харцагандаа үегүй

- A. багасгал
- B. Ихэсгэл
- C. тойруулал
- D. Төлөөлөл

7. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу Борзооны явдал” туужийн доорх хэсэгт ямар хэрэг явдлын талаар өгүүлж байна вэ? /2 оноо/

“... - Борзоон гэдэгт чинь хууртаад хүүхдүүд жинхэнэ хулгайчийг барих гэж бодохоо ч больсон. Ингэж “Борзоон” гэдэг нэрээр халхавч хийгээд нэг нөхөр манай сургуулийг санаа амар сүйтгэж байна. Тэр хулгайчид санаа амар хулгай дээрэм хийж явах бүх бололцоо, үүд хаалгыг чи нээж өгсөн... - - Үгүй ээ, багш аа. Тийм юм байхгүй... Дуугүй бай, нөхөр минь...”

A. Сурагч бодлогогүй ярианаасаа болж гүтгэгдэж буй тухай

B. Сурагч Борзоон нэрээр халхавч хийн хулгай хийсэн тухай

C. Багш хулгайчийг барьж, байцааж байгаа тухай

D. Хүүхдүүд хулгайчийг барих гэж бодохоо больсон тухай

8. “чих” гэдэг үйл үгийн олноороо үйлдэх утга илтгэсэн үгийг олоорой. /2 оноо/

A.

ᠴᠢᠬᠢ

B.

ᠴᠢᠬᠢ

C.

ᠴᠢᠬᠢ

D.

ᠴᠢᠬᠢ

9. “нэгүхү-ийн эмүн-э нутуг-ийан сонггу” гэсэн галигийг зөв бичсэн хэсэг аль вэ /2оноо/

A.

ᠨᠡᠭᠦᠬᠦ ᠶᠡᠨ ᠡᠮᠦᠨ ᠡ ᠨᠤᠲᠤᠭ ᠶᠡᠶ᠋ᠠᠨ ᠰᠣᠩᠭᠦ

B.

ᠨᠡᠭᠦᠬᠦ ᠶᠡᠨ ᠡᠮᠦᠨ ᠡ ᠨᠤᠲᠤᠭ ᠶᠡᠶ᠋ᠠᠨ ᠰᠣᠩᠭᠦ

C.

ᠨᠡᠭᠦᠬᠦ ᠶᠡᠨ ᠡᠮᠦᠨ ᠡ ᠨᠤᠲᠤᠭ ᠶᠡᠶ᠋ᠠᠨ ᠰᠣᠩᠭᠦ

D.

ᠨᠡᠭᠦᠬᠦ ᠶᠡᠨ ᠡᠮᠦᠨ ᠡ ᠨᠤᠲᠤᠭ ᠶᠡᠶ᠋ᠠᠨ ᠰᠣᠩᠭᠦ

### Шалгалтын түлхүүр

A хувилбар	B хувилбар	C хувилбар	D хувилбар	E хувилбар
1-D	1-D	1-A	1-B	
2-C	2-A	2-A	2-A	
3-A	3-A	3-D	3-D	
4-B	4-C	4-A	4-C	
5-A	5-D	5-C	5-A	
6-D	6-B	6-B	6-B	
7-B	7-C	7-B	7-A	
8- B	8-D	8-A	8-A	
9-B	9-B	9-C	9-B	